



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2019 / 5



АГУУЛГА



Хөдөлмөр



Эрүүл мэнд



Банк



Төсөв



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ



Хөдөө аж ахуй



Аж үйлдвэр



Гэмт хэрэг



Цахилгаан холбоо

Аргачлалын тайлбар

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Мөнгө, банк

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно. Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно. Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

Үнэ


Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг. Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний

үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж байна.



$P Q$

$ioio$

I_{ct}^L -t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t –тайлант үе, 0 – суурь үе,

P_{it} -'i' барааны тайлант үеийн үнэ,

P_{io} -'i' барааны суурь үеийн үнэ,

Q_{io} -'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

ct -нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

Хөдөө аж ахуй

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал

түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг хавцалд унах зэрэг хариулга маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар төсвийн ангиллаар 2015 оны 1 дүгээр сараас эхлэн гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг.

Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхитэй хүн ам (ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч , нийлүүлэхэд бэлэн байгаа ажилдгүй иргэдийг хамруулна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2019 оны 05 дугаар сарын байдал)

Бүртгэлтэй ажилгүй иргэн


Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны 5 дугаар сарын эцэст 831 байгаа нь өмнөх оны мөн үеэс 31 (3.9%) хүнээр өсч, өмнөх сараас 66 (7.4%) хүнээр буурч, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 452 (54.4%) эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн 13 (1.6%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ба тэдгээрийн 7 (53.8%) нь эмэгтэйчүүд байна.

2019 оны 5 дугаар сард ажилгүй 114 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 28 иргэн ажилд зуулчлагдан орж, 152 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хувьд ажил хайж буй шалтгаанаар нь задлан харахад хамгийн өндөр хувийг сургууль төгссөн иргэд 27.2 хувь нь, хамгийн бага хувийг хорих газраас суллагдсан иргэд буюу 3.2 хувь нь эзэлж байна.


Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 48.4 хувийг бүрэн дунд, 29.2 хувийг дипломын болон бакалаврын дээд, 9.5 хувийг техник мэргэжлийн, 5.7 хувийг суурь, 3.1 хувийг тусгай мэргэжлийн дунд, 2.4 хувийг бага, 1.7 хувийг ямар ч боловсролгүй иргэд эзэлж байна.

Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 56.0 хувийг 15-34 насны залуучууд, 40.3 хувийг 35-54 насныхан, 3.7 хувийг 55 дээш насныхан тус тус эзэлж байна


Хөдөлмөр, Халамжийн газарт бүртгэлтэй ажилгүй иргэд жил бүрийн 5 сарын байдлаар



Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр 2019 оны эхний 5 сарын байдлаар




Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2019 оны 5 сарын эцэст



Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 5 сарын байдлаар 564 эх амаржиж, 572 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 56 (11.0%)-аар, амьд төрсөн хүүхэд 57 (11.1%)-аар тус тус нэмэгдсэн байна. Энэ оны 5 дугаар сард 117 эх амаржиж, 117 хүүхэд төрүүлсэн нь өмнөх сараас амаржсан эх 4 (3.3%)-аар, амьд төрсөн хүүхэд 8 (6.4%)-аар буурсан байна.




Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл 2019 оны эхний 5 сард 14 болж, өмнөх оны мөн үеэс 4 (40.0%)-аар, тав хүртэлх хүүхдийн эндэгдэл 3 болж, өмнөх оны мөн үеэс 1 (50.0%) -аар нэмэгдсэн байна.


Халдварт өвчнөөр өвчлөгчид 170 болж, өмнөх оны мөн үеэс 88 (34.1%)-аар буурахад гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 69 (86.3%)-аар, хачигт реккетиоз өвчнөөр өвчлөгчид 22 (91.7%)-аар, салхинцэцэг өвчнөөр өвчлөгчид 9 (10.6%)-аар, тэмбүү 11 (26.2%)-аар, трихоминиаз өвчнөөр өвчлөгчид 8 (80.0%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин

заг хүйтэн өвчнөөр өвчлөгчид 18 (3.6 дахин), сүрьеэ өвчнөөр өвчлөгчид 6 (1 дахин) өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Халдварт өвчний төрлөөр 2019 оны 5 сарын байдлаар



Банк

Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2019 оны 5 дугаар сарын эцэст 104.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 8.0 тэрбум төгрөг буюу 7.1 хувиар буурчээ.

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст сая төг

Үзүүлэлт	Хугацаа	
	2018-V	2019-V
Мөнгөний нийлүүлэлт M2	112676.1	104725.5
Сарын өөрчлөлт, хувиар	46.7	-7.1
Нийт хадгаламж	83538.0	87179.8
Сарын өөрчлөлт, хувиар	39.5	4.4
Төгрөгийн хадгаламж	83373.9	86932.6
Сарын өөрчлөлт, хувиар	39.7	4.3
Валютын хадгаламж	164.1	247.2
Сарын өөрчлөлт, хувиар	-4.5	50.7

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 8.4 тэрбум төгрөг буюу 78.5 хувиар буурчээ.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 5 дугаар сарын эцэст 122.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 25.8 тэрбум төгрөг буюу 26.7 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 5 дугаар сарын эцэст 803.8 сая төгрөг болж, өмнөх оноос 101.8 сая төгрөг буюу 14.5 хувиар өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж байна.

Чанаргүй зээл 2019 оны 5 дугаар сарын эцэст 964.8 сая төгрөг болж өмнөх оноос 121.8 сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.8 хувийг эзэлж байна.

Үнэ


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2019 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.5 хувь, өмнөх оны жилийн эцсээс 5.3 хувь, өмнөх сараас 2.2 хувиар өссөн байна. Ерөнхий индекс 2019 оны 5 дугаар сард өмнөх сараас 2.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 9.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2019-05 2018-05	2019-05 2018-12	2019-05 2019-04
Ерөнхий индекс	100.0	108.5	105.3	102.2
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	119.4	124.7	109.1
Согтууруулах ундаа, тамхи	3.2	100.1	100.0	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	101.3	100.2	100.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	102.0	100.2	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	105.2	104.4	100.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	100.7	101.2	100.8
Тээвэр	12.2	108.3	99.9	100.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	101.7	99.6	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	101.7	101.7	101.1
Боловсролын үйлчилгээ	4.7	127.4	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	100.1	100.1	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	103.0	100.7	100.0


Ерөнхий индекс 2019 оны 5 дугаар сард оны жилийн эцсээс 5.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 24.7 хувь, хувцас, гэр ахуйн тавилга, бараа бүлгийн индекс 4.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)




Төсвийн орлого

Орон нутгийн төсөвт нийт 26.3 тэрбум төгрөг бүрдэж, төлөвлөгөө 101.8 хувиар, үүнээс улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 7.4 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 100.0 хувиар, тусгай зориулалтын шилжүүлэг 13.9 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 99.4 хувиар, орон нутгийн хөгжлийн сан 2.0 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 97.8 хувиар, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 3 тэрбум төгрөгт хүрч 124.0 хувиар, татварын орлого 2.5 тэрбум төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 108.3 хувиар, татварын бус орлого 527.7 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 2 дахин их биелүүлсэн байна. Аймгийн төсөвт байгууллагууд 2.5 сая төгрөгийн авлагатай, 257.1 сая төгрөгийн өглөгтэй байна.




Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн гүйцтгэл 22.7 тэрбум төгрөгт хүрч 77.0 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 94.1, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 94.0, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 88.2, нормативт зардал 64.2, эд хогшил, урсгал засварын зардал 51.3, томилолт, зочны зардлын 72.1, хөрөнгийн зардлын 42.1 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.




Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2019 оны 5 дугаар сарын байдлаар төллөх насны 1570.8 мянган хээлтэгч малын 1038.8 мянга буюу 66.1 хувь нь төллөсөн байна. Эм ямааны 64.1 хувь, эм хонины 74 хувь, ингэний 39.5 хувь, үнээний 50.7 хувь, гүүний 43.9 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 96.9 хувь буюу 1008.1 мянган төл бойжиж байна. Том малын зүй бусын хорогдол 2019 оны 5 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 33974 толгой болж, өмнөх оны мөн үетэй харьцуулвал 84.1 мянга буюу 3.5 дахин буурсан байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 1345, үхэр 1592, тэмээ 48, хонь 10044, ямаа 20945 байна. Нийт хорогдлын 29.6 хувийг хонь, 61.7 хувийг ямаа эзэлж байна.



Хорогдсон төл, 2019 оны 5-р сарын байдлаар, сумаар



Хорогдсон том мал, 2019 оны 5-р сарын байдлаар




Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2019 оны 5 дугаар сард аймгийн төв болох Есөнбулаг суманд ноолуур 88.0 мян.төг, хонины арьс 1.5 мян.төг, ямааны ноолуургүй арьс 500 төгрөг байна.


Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл тавдугаар сард өссөн дүнгээр 4.9 тэрбум төгрөг, үүнээс 78.8 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, 6.6 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 14.6 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар тус тус эзэлж байна. Нийт 1 тэрбум 131.1 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт /сая төгрөг/



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл салбараар, 2019 оны 5 сарыг байдлаар, хувиар




ЦАХИЛГААН ХОЛБОО

Суурин телефон цэгийн тоо 531, холбоо ашиглалтын орлого 130.6 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 91.4 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний нэг цэгээр 16 суудалтай ажиллаж, интернетээр дунджаар 0.2 мянган хүнд үйлчилжээ.

Харилцаа холбооны үйлчилгээний орлого сая төг




Суурин утасны цэгийн тоо



2019 ОНЫ 6 ДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Говь-Алтай нутаг. Агаарын температурын сарын дундаж нь нутгийн хойд хагаст 11-16 градус, өмнөд хагаст 15-20 градус дулаан буюу ихэнх нутгаар уур амьсгалын дунджийн орчим байна.




Нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр Алтайн уулархаг нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 19-24 градус, Алтайн өвөр говиор шөнөдөө 14-19 градус, өдөртөө 29-34 градус, бусад нутгаар шөнөдөө 10-15 градус, өдөртөө 24-29 градус дулаан байна.

Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр сэрүүсч Алтайн уулархаг нутгаар шөнөдөө 3 градус дулаанаас 2 градус хүйтэн, өдөртөө 8-13 градус, Алтайн өвөр говиор шөнөдөө 7-12 градус, өдөртөө 22-27 градус, бусад нутгаар шөнөдөө 4-9 градус, өдөртөө 17-22 градус дулаан байна.

Бусад хугацаанд Алтайн уулархаг нутгаар шөнөдөө 2-7 градус, өдөртөө 15-20 градус, Алтайн өвөр говиор шөнөдөө 11-16 градус, өдөртөө 25-30 градус, бусад нутгаар шөнөдөө 6-11 градус, өдөртөө 21-26 градус дулаан байна.

Энэ сард Говь-Алтайн хойд хэсгээр уур амьсгалын дунджийн орчим, бусад нутгаар уур амьсгалын дунджаас бага бороо орох төлөвтэй.



Нэгдүгээр арав хоногийн эхэн ба сүүлч, хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр зарим газраар, хоёрдугаар арав хоногийн эхний хагас, гуравдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар бороо орно.

Дуу цахилгаантай. Дээрх бороо орох үеүдэд салхи зарим газраар 12-14 м/с, зарим үед дуу цахилгааны өмнө 18-20 м/с хүрч ширүүсч болзошгүй.

Эх сурвалж: Говь-Алтай УЦУОШТ-ийн УМХ Утас: 70483093

<http://govi-altai.tsag-agaar.gov.mn/forecast/month>



Хөдөлмөр

**ХӨДӨЛМӨР
LABOUR**

**БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны эцэст
NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of period**

Боловсролын түвшинээр	By educational level	2015.XII	2016.XII	2017.XII	2018.XII	5-сар In May	
						2018	2019
Бүгд	Total	1044	786	796	919	800	831
Үүнээс: эмэгтэй	of which:female	547	435	430	462	508	435
Дээд боловсролтой	Higher education	252	265	280	226	285	243
Тусгай дунд боловсролтой	Specialized secondary education	72	35	49	46	43	26
Мэргэжлийн анхан шатны	Professional technical and vocational training workers	81	70	66	72	73	79
Бүрэн дунд	Upper secondary school	483	341	331	475	327	402
Суурь	Compulsory secondary school	112	42	41	59	41	47
Бага	Primary school	35	28	27	23	28	20
Боловсролгүй	Uneducated persons	9	5	2	18	3	14

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, насны бүлгээр,
2019 оны 5 сарын эцэст
NUMBER OF UNEMPLOYED, by age group,
at the end of may 2019**

Үүнээс: насны бүлгээр of which:by age group

Сар Months	Бүгд Total	Үүнээс: эмэгтэй female	15-24	25-34	35-44	45-59	55-59	60+						
			Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female						
I														
II	879	430	183	93	290	145	230	119	147	63	20	6	9	4
III	811	395	184	98	267	126	197	103	135	59	21	7	7	2
IV	897	452	198	108	302	156	215	106	148	70	26	9	8	3
V	831	435	186	106	279	149	203	105	132	62	23	10	8	3

2019 ОНЫ 5 САРД АЖИЛГҮЙЧҮҮДЭЭС ТАЙЛАНТ САРД АЖИЛД ОРСОН ХҮН
NUMBER OF UNEMPLOYED ENTERED INTO WORK, in the 5 months of 2019

Сар Month	Бүгд Total	Төрийн өмчит үйлдвэрийн газарт	Төрийн төсөвт байгууллагад Government organization	Компани Company	Хоршоо Cooperative	Бусад Other
I						
II	7		5			2
III	40		29	2		9
IV	33	1	12	18		2
V	28		15	8		5

АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМААР
NUMBER OF UNEMPLOYED, by som

Нои	Sum	Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed						
		2015.XII	2016.XII	2017.XII	2018.XII	5-р сар		
						may		
						2018	2019	2019%
Есөнбулаг	Yesunbulag	284	326	353	487	463	403	87.0
Алтай	Altai	40	10	27	17	21	11	52.4
Баян-Уул	Bayan-Uul	22	40	28	30	26	30	115.4
Бигэр	Biger	56	35	24	29	24	30	125.0
Бугат	Bugat	26	19	31	30	22	22	100.0
Дарив	Darib	47	17	12	54	13	66	507.7
Дэлгэр	Delger	45	44	75	24	28	21	75.0
Жаргалан	Jargalan	33	11	6	11	10	8	80.0
Тайшир	Taishir	17	15	16	3	13	4	30.8
Тонхил	Tonhil	68	20	11	30	9	18	200.0
Төгрөг	Tugrug	37	21	16	21	13	17	130.8
Халиун	Haliun	35	25	30	25	10	17	170.0
Хөхморьт	Huhmorit	15	34	16	12	15	8	53.3
Цогт	Tsogt	73	61	63	38	11	34	309.1
Цээл	Tseel	37	15	16	33	64	71	110.9
Чандмана	Chandmana	75	34	45	42	42	47	111.9
Шарга	Sharga	46	34	12	18	10	14	140.0
Эрдэнэ	Erdene	25	25	15	15	6	10	166.7
Бусад аймгууд болон УБ-т бүртгэлтэй	Other	63	-	-				
ДҮН	TOTAL	1044	786	796	919	800	831	103.9



Эрүүл мэнд

ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
PUBLIC HEALTH OF POPULATION

№	Сумын нэр	Soum	Төрсөн эх Women who gave births		Эхийн эндэгдэл Maternal Deaths		Төрсөн хүүхэд Births		Нялхасын эндэгдэл Infant mortality		1-5 хүртэлх настай хүүхдийн эндэгдэл Under-five mortality		Нийт нас баралт Deaths		Эмнэлэгт нас баралт Deaths	
			2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
1	Есөнбулаг	Yesunbulag	470	525			478	533	7	10		1	41	62	9	17
2	Алтай	Altai	3	5			3	5	0	0		1	1	3	1	0
3	Баян-Уул	Bayan-Uul	3				3		0	0		1	12	10	3	1
3	Бигэр	Biger	2	6			2	6	0	0		0	3	2		
4	Бугат	Bugat	2	2			2	2	0	0		0		8		1
5	Гуулин	Gulin	1				1		0	0		0	5	0		
5	Дарив	Darib	2	3			1	3	1	1		0	6	1	2	
6	Дэлгэр	Delger	2	2			2	2	0	0		0	7	1		
7	Жаргалан	Jargalan							1	0		0	2	2	1	
8	Тайшир	Taishir							1	0		0	3	7		
8	Тонхил	Tonhil	5	4			5	4	0	0	1	0	9	3	3	
9	Төгрөг	Tugrug	4	1			4	1	0	2		0	2	7		5
10	Халиун	Haliun	1	1			1	1	0	0		0	7	4	1	1
10	Хөхморьт	Huhmorit	1	2			1	3	0	1		0	7	7	4	4
11	Цогт	Tsogt		3				3	0	0	1	0	7	5	2	1
12	Цээл	Tseel	4	2			4	2	0	0		0	6	3	1	
12	Чандмана	Chandmani	4	5			4	5	0	0		0	3	5	1	
13	Шарга	Sharga							0	0		0	2	4		
14	Эрдэнэ	Erdene	4	3			4	2		0		0	1	4		
15	Баянтоорой	Bayantoroi							0	0		0	6	3	2	1
22	Дүн	Total	508	564	0	0	515	572	10	14	2	3	130	141	30	31

№	Сумын нэр	Soum	Цочмог халдварт өвчлөл бүгд Infectious Diseases		Үүнээс: Of which:															
			БЗХӨ STID										Гепатит Hepatite		Сүрьеэ Tuberculosis		Улаан бурхан		Бусад Other	
			2018	2019	Трихоминаз Trichomoniasis		Тэмбүү Syphilis		Заг хүйтэн Gonorrhea		2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019		
1	Есөнбулаг	Yesunbulag	180	85	5	1	10	14	2	17			5	5			158	48		
2	Алтай	Altai	2	1			2			1							0	0		
3	Баян-Уул	Bayan-Uul	2	12									1				2	11		
3	Бигэр	Biger	4	0			3										1	0		
4	Бугат	Bugat	12	9			7										5	9		
5	Гуулин	Gulin	1	1								1					1	0		
5	Дарив	Darib	1	3	1	1	0							1			0	1		
6	Дэлгэр	Delger	9	2			1	1	1	1	1						6	0		
7	Жаргалан	Jargalan	2	4			1	2		1			1				1	0		
8	Тайшир	Taishir	4	2				1									4	1		
8	Тонхил	Tonhil	3	3				2						1			3	0		
9	Төгрөг	Tugrug	7	0	1		5										1	0		
10	Халиун	Haliun	8	4			2	2									6	0		
10	Хөхморьт	Huhmorit	6	4			3	1		1			1	1			2	1		
11	Цогт	Tsogt	0	12				1		1							0	10		
12	Цээл	Tseel	3	2			2	2									1	0		
12	Чандмана	Chandmani	3	0			1										2	0		
13	Шарга	Sharga	2	2			1	1									1	1		
14	Эрдэнэ	Erdene	0	6						1							0	5		
15	Баянтоорой Харьяаллын	Bayantoroi	0	14													0	14		
16	бус		9	4	3		4	4	2								0	0		
22	Дүн	Total	258	170	10	2	42	31	5	23	1	1	6	12	0	0	194	101		



Банк, үнэ

МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ
MONEY, LOAN, STOCK MARKET

I. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ, сарын эцэст
MONEY SUPPLY, at the end of months

Хугацаа, сараар Periods, by months	Мөнгө M2 Money M2								Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө Currency issued in circulation
		Мөнгө M1 Money M1	Төгрөгийн харилцах Current account	Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө Currency outside depository corporations	Барар мөнгө Quasi money	Төгрөгийн хадгаламж Time deposit in DC	Валютын хадгаламж Time deposits in FC	Валютын харилцах Current account in FC	
2019 он									
I	102,976.03	16,969.58	16,174.65	794.93	86,006.46	85,513.53	458.77	34.16	2,670.57
II	97,863.84	11,942.19	12,948.36	(1,006.18)	85,921.66	85,453.72	457.36	10.58	861.65
III	95,111.46	11,450.77	12,681.59	(1,230.81)	83,660.69	83,253.75	372.97	33.97	380.00
IV	94,046.51	12,438.35	12,186.09	252.26	81,608.16	81,349.74	236.85	21.57	1,828.10
V	104,725.51	17,520.91	17,792.26	(271.35)	87,204.60	86,932.61	247.23	24.77	2,312.33

II. АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, зээлийн ангиллаар, сарын эцэст
LOANS OUTSTANDING, by classification of loan, at the end of months

Хугацаа, сараар Periods, by months	Зээлийн өрийн үлдэгдэл Laons outstanding	Хэвийн зээл Standart loans	Хугацаа хэтэрсэн зээл Principal in arrears	Чанаргүй зээл Non performing laons	сая төг mln.tog			
					Төрийн салбар Public sector	Хувийн салбар Private sector	Иргэд Individuals	Бусад Other
2019 он								
I	124,934.48	123,420.50	609.96	904.02	-	26.13	877.89	-
II	123,456.50	121,591.49	939.34	925.67	-	26.13	899.54	-
III	123,865.55	121,982.64	966.73	916.17	-	26.13	890.04	-
IV	124,587.53	122,786.24	868.59	932.70	-	26.13	906.57	-
V	122,563.67	120,795.07	803.79	964.81	-	-	-	-

Монгол банкнаас гаргадаг мэдээний загвар өөрчлөгдсөн учир чанаргүй зээлийн задаргаа сараар гарахгүй

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 5 дугаар сард, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Аймаг, нийслэл Aimag and the Capital	Ерөнхий индекс	Хүнсний бараа, ундаа, ус	Согтууруулах ундаа, тамхи	Хувцас, бөс бараа, гутал	Орон сууц, ус, цахилгаан, түлш	Гэр ахун тавилга, гэр ахуйн бараа	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	Тээвэр	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	Боловсролын үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	Бусад бараа, үйлчилгээ
	Overall index	Food and non- alcoholic beverages	Alcoholic beverages, tobacco	Clothing, footwear and cloth	Housing, water electricity and fuels	Furnishings, household equipment	Health	Transport	Communication	Recreation and culture	Education	Restaurants and hotels	Miscellaneous goods & services
2019.01	107.0	109.9	103.6	102.9	112.9	106.9	102.8	111.8	100.8	96.6	118.2	101.5	102.0
2019.02	105.6	106.9	103.1	102.5	106.4	106.5	102.7	110.0	100.8	96.6	118.2	102.3	101.0
2019.03	104.7	106.0	103.7	103.8	106.9	104.1	101.6	104.9	102.6	103.2	107.3	97.4	101.9
2019.04	106.5	110.8	100.7	101.1	102.4	104.9	100.4	107.8	101.7	100.7	127.4	100.1	103.0
2019.05	106.5	110.8	100.7	101.1	102.4	104.9	100.4	107.8	101.7	100.7	127.4	100.1	103.0

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 5 дугаар сард, өмнөх оны жилийн эцэстэй харьцуулснаар

Аймаг, нийслэл Aimag and the Capital	Ерөнхий индекс	Хүнсний бараа, ундаа, ус	Согтууруулах ундаа, тамхи	Хувцас, бөс бараа, гутал	Орон сууц, ус, цахилгаан, түлш	Гэр ахун тавилга, гэр ахуйн бараа	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	Тээвэр	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	Боловсролын үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	Бусад бараа, үйлчилгээ
	Overall index	Food and non- alcoholic beverages	Alcoholic beverages, tobacco	Clothing, footwear and cloth	Housing, water electricity and fuels	Furnishings, household equipment	Health	Transport	Communication	Recreation and culture	Education	Restaurants and hotels	Miscellaneous goods & services
2019.01	101.0	104.5	100.8	100.6	101.9	100.5	98.7	99.2	100.0	100.0	99.6	101.5	100.9
2019.02	101.0	105.6	101.1	100.6	100.5	100.5	99.1	98.5	100.0	100.0	99.6	102.4	100.9
2019.03	101.4	103.6	100.9	102.1	101.5	100.9	100.9	97.4	100.0	100.1	99.9	102.3	100.9
2019.04	103.1	114.4	100.0	100.2	100.3	104.1	100.4	99.4	99.6	100.7	100.0	100.1	100.7
2019.05	103.1	114.4	100.0	100.2	100.3	104.1	100.4	99.4	99.6	100.7	100.0	100.1	100.7

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 5 дугаар сард, өмнөх сартай харьцуулснаар

Аймаг, нийслэл Aimag and the Capital	Ерөнхий индекс	Хүнсний бараа, ундаа, ус	Согтууруулах ундаа, тамхи	Хувцас, бөс бараа, гутал	Орон сууц, ус, цахилгаан, түлш	Гэр ахун тавилга, гэр ахуйн бараа	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	Тээвэр	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	Боловсролын үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	Бусад бараа, үйлчилгээ
	Overall index	Food and non- alcoholic beverages	Alcoholic beverages, tobacco	Clothing, footwear and cloth	Housing, water electricity and fuels	Furnishings, household equipment	Health	Transport	Communication	Recreation and culture	Education	Restaurants and hotels	Miscellaneous goods & services
2019.01	101.0	104.5	100.8	100.6	101.9	100.5	98.7	99.2	100.0	100.0	99.6	101.5	100.9
2019.02	100.0	101.0	100.3	100.0	98.7	100.0	100.4	99.3	100.0	100.0	100.0	100.9	100.0
2019.03	100.4	100.8	100.0	100.9	100.0	100.1	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
2019.04	101.2	104.5	100.0	100.2	100.8	100.6	100.0	100.3	100.0	99.9	100.0	100.0	100.0
2019.05	101.2	104.5	100.0	100.2	100.8	100.6	100.0	100.3	100.0	99.9	100.0	100.0	100.0



Төсөв

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
GOVI-ALTAI AIMAGS GOVERNMENT REVENUE, by classification of revenue

		<i>мян.мөг thous.tug</i>		
ОРЛОГЫН ТӨРӨЛ	INCOME TYPE	Төлөвлөгөө <i>Project</i>	* Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
НИЙТ ОРЛОГО		25,861,697.3	26,315,378.0	101.8
УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОСОН				
САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ		7,401,033.5	7,401,033.5	100.0
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ		13,939,321.0	13,852,404.6	99.4
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН		2,082,446.0	2,037,059.8	97.8
ШИЛЖЭЭГҮЙ ҮЛДЭГДЭЛ				
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		2,438,896.8	3,024,880.1	124.0
1.ТАТВАРЫН ОРЛОГО		2,238,355.1	2,424,068.9	108.3
1.1 Орлогын албан татвар		1,674,699.0	1,887,638.0	112.7
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар		2,224,699.0	2,336,962.1	105.0
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого		1,723,206.5	1,825,710.1	105.9
Үйл ажиллагааны орлого		41,187.5	44,007.0	106.8
Хөрөнгийн орлого		393,973.5	420,220.5	106.7
Хөрөнгө борлуулсны орлого		29,150.0	23,819.4	81.7
Шууд бус орлого		37,181.5	23,205.1	62.4
1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(550,000.0)	(449,324.1)	81.7
1.2 Хөрөнгийн албан татвар		244,109.6	256,962.1	105.3
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		94,595.1	57,348.2	60.6
Галт зэвсгийн албан татвар		15,124.5	9,502.8	62.8
татвар		134,390.0	190,111.1	141.5
Малд ногдуулах албан татвар		-	-	0.0
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж		319,546.5	279,468.8	87.5
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж		127,940.5	129,247.9	101.0
Улсын тэмдэгтийн хураамж		62,792.5	72,971.6	116.2
Улсын тэмдэгтийн хураамжийн буцаан олголт		(5,000.0)	(1,434.0)	28.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		2,350.0	2,486.7	105.8
Хог хаягдлын хураамжийн төлбөр		67,798.0	55,223.6	81.5
1.3.2 Газрын төлбөр		156,466.0	86,868.9	55.5
Үүнээс: Газрын төлбөр		156,466.0	86,868.9	55.5
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт		-	-	0.0
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр		34,842.0	53,844.4	154.5
Үүнээс: Ойн нөөц ашигласны төлбөр		-	139.2	0.0
Ан, амьтны нөөц ашигласны төлбөр		4,617.0	28,331.5	613.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		30,225.0	25,373.7	83.9
Байгалийн ургамал ашигласны төлбөр		-	-	0.0
1.3.4 Бусад татвар		298.0	9,507.6	0.0
2. Татварын бус орлого		200,541.7	527,701.2	263.1
Хүү, торгуулийн орлого		181,659.0	487,838.2	268.5
Төсвийн байгууллагын өөрийн орлого		-	-	0.0
Түрээсийн орлого		3,882.7	4,205.0	108.3
Бусад орлого		15,000.0	35,658.0	237.7
3. Хөрөнгийн орлого		-	73,110.0	0.0
Өмч хувьчлалын орлого		-	73,110.0	0.0
УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		531,810.0	952,730.7	179.1
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар		51,900.0	98,041.1	188.9
НӨАТатвар		442,400.0	811,412.4	183.4
Онцгой албан татвар		18,000.0	15,200.0	84.4
Агаарын бохирдлын төлбөр		15,310.0	12,428.7	81.2
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		4200.0	15648.5	0.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА
EXPENDITURE OF PROVINCIAL GOVERNMENT

/мян.мөг, thous.tug/

Төрөл type	Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,477,235.8	22,709,536.1	77.0
НИЙТ ЗАРЛАГА	27,916,953.2	22,547,319.3	80.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,193,447.5	21,308,677.4	88.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,596,028.5	20,513,734.9	86.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,894,431.7	13,079,965.3	94.1
Үндсэн цалин	11,393,000.1	10,808,261.8	94.9
Нэмэгдэл	596,010.0	456,192.9	76.5
Унаа хоолны хөнгөлөлт	79,335.8	69,647.1	87.8
Урамшуулал	900,776.0	835,983.9	92.8
Гэрээт ажлын хөлс	925,309.8	909,879.6	98.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,731,041.7	1,627,913.1	94.0
Тэтгэврийн даатгал	1,179,265.6	1,122,601.3	95.2
Тэтгэмжийн даатгал	137,944.7	130,322.0	94.5
ҮОМШӨ-ний даатгал	110,357.7	102,604.6	93.0
Ажилгүйдлийн даатгал	27,586.6	25,734.5	93.3
Эрүүл мэндийн даатгал	275,887.1	246,650.6	89.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,969,121.3	2,619,246.8	88.2
Гэрэл, цахилгаан	206,062.1	180,941.9	87.8
Түлш, халаалт	2,680,586.6	2,379,267.6	88.8
Цэвэр, бохир ус	0.0	0.0	0.0
Байрны түрээс	82,472.6	59,037.3	71.6
Хангамж, бараа материалын зардал	623,866.0	487,386.2	78.1
Бичиг хэрэг	61,722.0	47,671.1	77.2
Тээвэр, шатахуун	391,892.1	327,166.2	83.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,982.0	40,593.6	70.0
Ном, хэвлэл	30,776.4	12,230.7	39.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,813.5	7,454.6	35.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,680.0	52,270.1	86.1
Нормативт зардал	1,120,612.8	719,265.0	64.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	165,772.7	87,012.1	52.5
Хоол, хүнс	901,333.2	620,096.5	68.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	53,506.9	12,156.4	22.7
Эд хогшил, урсгал засварын зардал	856,091.0	439,031.3	51.3
Багаж, техник, хэрэгсэл	242,085.4	163,631.3	67.6
Тавилга	39,378.2	2,804.0	7.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,275.0	2,008.3	38.1
Урсгал засвар	569,352.4	270,587.6	47.5
Томилолт, зочны зардал	217,593.3	156,859.4	72.1
Гадаад албан томилолт	217,593.3	156,859.4	72.1
Дотоод албан томилолт	0.0	0.0	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,			
хураамж	1,596,307.5	942,931.7	59.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил			
үйлчилгээний төлбөр хураамж	1,381,959.3	774,326.0	56.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	61,465.5	47,552.0	77.4
Даатгалын үйлчилгээ	21,475.0	14,498.8	67.5
Тээврийн хэрэгслийн татвар	6,418.0	2,888.8	45.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,972.6	644.0	21.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	107,095.2	96,954.0	90.5
Газрын төлбөр	3,180.4	600.5	18.9
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,441.5	1,451.7	26.7

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

Үргэлжлэл
мян.төг, tous.tog

	Төлөвлөгөө <i>Project</i>	* Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	6,300.0	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,334,035.6	586,963.2	44.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,190,234.0	504,014.3	42.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	143,801.6	82,948.9	57.7
ТАТААС	20,000.0	11,666.9	58.3
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000.0	11,666.9	58.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,220,397.7	585,752.1	48.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	287,000.0	71,750.0	25.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	287,000.0	71,750.0	25.0
Бусад урсгал шилжүүлэг	933,397.7	514,002.1	55.1
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	105,000.0	86,000.0	81.9
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	567,670.7	288,786.0	50.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,956.3	26,411.1	41.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан ал	0.0	0.0	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,770.7	112,805.0	57.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,852,370.2	3,723,505.7	42.1
Бусад хөрөнгө	8,852,370.2	3,723,505.7	42.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,660,881.6	1,560,282.6	93.9
Эргэж төлөгдөх зээл	1,660,881.6	1,560,282.6	93.9
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-4,032,757.5	-3,759,131.2	93.2
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,032,757.5	3,759,131.2	93.2
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	4,003,469.8	3,759,131.2	93.9
Өмч хувьчлал	29,287.7	0.0	0.0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,003,469.8	3,759,131.2	0.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар
PERFORMANCE REVENUE soum

мян.төг thous.tug

№	Сум	Soum	Нийт орлого		Хувь Rate
			Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	
1	Есөнбулаг	Yesunbulag	358,075.0	324,968.3	97.6
2	Алтай	Altai	13,840.0	21,978.4	104.6
3	Баян-Уул	Bayn-Uul	26,882.5	21,576.6	123.1
4	Бигэр	Biger	12,718.0	16,671.7	156.5
5	Бугат	Bugat	15,766.0	21,892.4	142.3
6	Дарив	Dariv	13,925.0	20,268.0	113.6
7	Дэлгэр	Delger	14,100.0	13,977.4	130.6
8	Жаргалан	Jargalan	10,373.0	20,023.7	143.7
9	Тайшир	Taishir	6,945.5	8,772.0	116.3
10	Тонхил	Tonhil	33,917.0	76,946.3	150.0
11	Төгрөг	Tugrug	24,192.9	24,044.1	114.9
12	Халиун	Khaliun	6,699.0	12,286.8	133.2
13	Хөхморьт	Khukhmorit	13,780.0	14,835.1	111.3
14	Цогт	Tsogt	16,150.0	18,333.0	106.5
15	Цээл	Tseel	23,238.0	34,596.5	117.5
16	Чандмань	Chandmani	17,820.0	14,478.8	123.6
17	Шарга	Sharga	10,770.0	14,131.0	129.6
18	Эрдэнэ	Erdene	13,066.5	16,786.0	182.0
19	Баянтоорой тосгон	Bayntooroi	6,000.0	6,047.5	143.7
20	Гуулин тосгон	Guulin	5,780.8	7,203.1	182.0
21	Татварын хэлтэс	Straight communicant	1,794,857.6	2,315,063.4	111.6
Дүн			2,438,896.8	3,024,880.1	112.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар

PERFORMANCE REVENUE soum

мян.мөг, thous.tug

№	Сум	Soum	Орон нутаг Provincial government		
			Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
1	Есөнбулаг	Yesunbulag	6040775.1	6040775.1	100.0
2	Алтай	Altai	1109403.1	1109403.1	100.0
3	Баян-Уул	Bayn-Uul	847790.3	847790.3	100.0
4	Бигэр	Biger	827811.1	827811.1	100.0
5	Бугат	Bugat	1003448.8	1003448.8	100.0
6	Дарив	Dariv	904813.2	904813.2	100.0
7	Дэлгэр	Delger	945398.4	1032314.8	109.2
8	Жаргалан	Jargalan	796734.4	889783.6	111.7
9	Тайшир	Taishir	889175.8	889175.8	100.0
10	Тонхил	Tonhil	989226.8	1096624.9	110.9
11	Төгрөг	Tugrug	794068.4	794068.4	100.0
12	Халиун	Khaliun	999443.6	1094611.6	109.5
13	Хөхморьт	Khukh morit	892171.7	893171.7	100.1
14	Цогт	Tsogt	1044624.2	1044624.2	100.0
15	Цээл	Tseel	941427.2	941427.2	100.0
16	Чандмань	Chandmani	954189.6	954189.6	100.0
17	Шарга	Sharga	871446.8	871446.8	100.0
18	Эрдэнэ	Erdene	1327684.4	1328294.4	100.0
19	Гуулин тосгон	Guulin	489937.8	547751.5	111.8
20	Баянтоорой тосгон	Bayntooroi	546416.0	546416.0	100.0
21	Говь-Алтай аймаг шууд харилцагч	Straight communicant	9543364.3	9108923.3	95.4
Дүн			32759351.0	32766865.4	100.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more



Аж үйлдвэр

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН салбараар, (оны үнээр, мян.төг)
GROSS INDUSTRIAL OUTPUT, sector at current price thous.tug

Салбараар	2018 IV	2018 I-IV	2019 IV*	2019 I-IV*	<u>2019 I-IV*</u> 2018 I-IV
A	1	2	3	4	5
Нийт дүн	418396.8	3589337.3	933560.6	4930991.5	137.4
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	56106.8	725106.3	154106.7	717933.8	99.0
Нүүрс олборлолт	49840.0	718839.5	151284.1	703560.3	97.9
Төмрийн хүдэр олборлолт	6266.8	6266.8	2822.6	14373.5	0.0
Боловсруулах аж үйлдвэр	47184.6	500979.4	75305.4	323883.1	64.6
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	34474.2	466582.0	60862.4	294113.1	63.0
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	660.0	9900.0	1544.0	14553.1	147.0
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	0.0	12000.0	12600.0	45750.0	381.3
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9908.0	282491.6	22195.8	105767.0	37.4
Ундаа үйлдвэрлэл	23906.2	162190.4	24522.6	128043.0	78.9
Нэхмэлийн үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	4035.0	14169.0	7420.0	14945.0	105.5
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	0.0	4417.0	209.0	2509.0	56.8
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	176.0	2657.0	424.0	2836.0	106.7
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	1635.5	1635.5	4770.0	4770.0	0.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	6863.9	6863.9	960.0	960.0	0.0
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	0.0	4655.0	660.0	3750.0	80.6
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	315105.4	2363251.6	704148.5	3889174.6	164.6
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	236959.9	1976056.9	569566.6	3252633.5	164.6
Ус ариутгал, усан хангамж	78145.5	387194.7	134581.9	636541.1	164.4

* Урьдчилсан гүйцэтгэл

* Times more

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ

салбараар, (оны үнээр, мян.төг)

GROSS INDUSTRIAL OUTPUT, sector by soum, at current price thous.tug

Салбараар	2018 IV	2018 I-IV	2019 IV*	2019 I-IV*	$\frac{2019 \text{ I-IV}^*}{2018 \text{ I-IV}}$
A	1	2	3	4	5
Нийт дүн	468812.1	4287364.4	894306.8	5077021.8	118.4
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	42260.3	742455.0	107536.8	807771.9	108.8
Нүүрс олборлолт	31826.3	732021.0	104714.2	786834.3	107.5
Төмрийн хүдэр олборлолт	10434.0	10434.0	2822.6	20937.6	0.0
Боловсруулах аж үйлдвэр	42800.5	538022.2	98021.5	382827.4	71.2
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	31293.5	496192.2	75934.5	335711.2	67.7
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	780.0	11868.0	1900.0	17763.3	149.7
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	0.0	18000.0	18400.0	67150.0	373.1
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	13081.1	334606.9	35618.5	154589.3	46.2
Ундаа үйлдвэрлэл	17432.4	131717.3	20016.0	96208.6	73.0
Нэхмэлийн үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	6850.0	22199.0	11602.0	21838.0	98.4
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	0.0	6129.0	280.0	3454.0	56.4
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	300.0	3370.0	945.0	8844.2	262.4
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	2557.0	2557.0	6890.0	6890.0	0.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	1800.0	1800.0	1500.0	1500.0	0.0
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	0.0	5775.0	870.0	4590.0	79.5
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	383751.3	3006887.2	688748.5	3886422.5	129.3
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	332303.4	2719688.2	621709.2	3503054.1	128.8
Ус ариутгал, усан хангамж	51447.9	287199.0	67039.3	383368.4	133.5

* Урьдчилсан гүйцэтгэл

* Times more



Хөдөө аж ахуй

Төллөсөн хээлтэгч, Гарсан төл, Бойжсон төл, 2019 оны 5-р сарын байдлаар

Сум	Төллөсөн хээлтэгч						Гарсан төл						Бойжсон төл					
	Бүгд	Гүү	Үнээ	Ингэ	Эм хонь	Эм ямаа	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг
	1038752	18191	16864	5807	365183	632707	1040007	18191	16864	5807	365814	633331	1008109	17532	16293	5686	354006	614592
Есөнбулаг	77457	1687	1497	144	29648	44481	77457	1687	1497	144	29648	44481	75418	1645	1456	139	28901	43277
Алтай	51810	645	756	368	9808	40233	51810	645	756	368	9808	40233	51354	642	746	366	9650	39950
Баян-Уул	30044	232	212	116	12681	16803	30044	232	212	116	12681	16803	28341	222	208	114	11759	16038
Бигэр	18170	352	481	242	4292	12803	18170	352	481	242	4292	12803	17834	341	470	235	4174	12614
Бугат	46203	238	237	144	15954	29630	46203	238	237	144	15954	29630	46203	238	237	144	15954	29630
Дарив	44500	743	938	279	16485	26055	44596	743	938	279	16516	26120	43994	728	903	272	16269	25822
Дэлгэр	106146	1292	1162	479	41280	61933	106146	1292	1162	479	41280	61933	105591	1288	1151	473	41169	61510
Жаргалан	65005	639	877	138	23377	39974	66124	639	877	138	23937	40533	64207	633	870	134	23030	39540
Тайшир	40489	564	580	85	19440	19820	40529	564	580	85	19480	19820	39631	544	555	82	19060	19390
Тонхил	87037	1818	1225	38	47082	36874	87037	1818	1225	38	47082	36874	78044	1719	1107	34	43954	31230
Төгрөг	34821	1207	665	772	13315	18862	34821	1207	665	772	13315	18862	31299	1156	644	772	12165	16562
Халиун	92668	1510	1830	586	30900	57842	92668	1510	1830	586	30900	57842	91245	1483	1792	566	30615	56789
Хөхморьт	32858	2140	1520	268	12600	16330	32858	2140	1520	268	12600	16330	31628	2140	1520	268	12047	15653
Цогт	82366	971	1512	489	22552	56842	82366	971	1512	489	22552	56842	81422	960	1486	478	22237	56261
Цээл	72668	1448	1175	165	16810	53070	72668	1448	1175	165	16810	53070	71113	1256	1083	159	16331	52284
Чандмань	67839	1490	972	219	23235	41923	67839	1490	972	219	23235	41923	64545	1375	882	198	21792	40298
Шарга	58263	959	1010	1100	14724	40470	58263	959	1010	1100	14724	40470	57855	946	993	1082	14584	40250
Эрдэнэ	30408	256	215	175	11000	18762	30408	256	215	175	11000	18762	28385	216	190	170	10315	17494

Хорогдсон том мал, Хорогдсон төл, 2019 оны 5-р сарын байдлаар

Сум	Хорогдсон том мал						Хорогдсон төл					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг
	33974	1345	1592	48	10044	20945	31898	659	571	121	11808	18739
Есөнбулаг	1829	146	145	0	462	1076	2039	42	41	5	747	1204
Алтай	699	8	36	18	198	439	456	3	10	2	158	283
Баян-Уул	4928	322	204	0	2292	2110	1703	10	4	2	922	765
Бигэр	711	24	34	5	266	382	336	11	11	7	118	189
Бугат	1642	0	0	1	146	1495						
Дарив	935	174	96	6	326	333	602	15	35	7	247	298
Дэлгэр	2429	37	79	1	439	1873	555	4	11	6	111	423
Жаргалан	5334	17	85	3	1987	3242	1917	6	7	4	907	993
Тайшир	2207	134	153	0	640	1280	898	20	25	3	420	430
Тонхил	2912	159	273	5	786	1689	8993	99	118	4	3128	5644
Төгрөг	1236	55	22	0	172	987	3522	51	21	0	1150	2300
Халиун	1420	58	110	1	519	732	1423	27	38	20	285	1053
Хөхморьт	1888	21	32	0	442	1393	1230	0	0	0	553	677
Цогт	759	5	58	0	146	550	944	11	26	11	315	581
Цээл	1734	70	67	1	259	1337	1555	192	92	6	479	786
Чандмань	1164	52	88	6	389	629	3294	115	90	21	1443	1625
Шарга	966	28	45	0	273	620	408	13	17	18	140	220
Эрдэнэ	1181	35	65	1	302	778	2023	40	25	5	685	1268

Бусад



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
 MAIN INDICATORS OF TELECOMMUNICATION SECTOR

Төрөл	Type	Өмнөх оны мөн үед Previous year	2019 оны V* сард		
			Төлөвлөгөө Project	Гүйцэтгэл Performance	Хувь Percent
Харилцаа холбооны үйлчилгээний орлого мян.төг	<i>Revernue from telecommunication services thous.tog</i>	89528.3	137523.4	130583.7	95.0
Хүн амаас олсон орлого мян.төг	<i>Revernue from population thous.tog</i>	62669.0	96266.1	91409	95.0
Суурин утасны цэгийн тоо	<i>Number of telleprnone lines</i>	570	533	531	99.6
Үүнээс: Хүн амаас Суурин утасны цэгийн тоо	<i>of which population telleprnone lines</i>	399	390	377	96.7

Эх үүсвэр: Холбооны газар

* Урьдчилсан гүйцэтгэл

* Times more